



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

126 /126/

2021.09.02

## “ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ-БАТЛАН ХАМГААЛАХЫН УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН СУРГАЛТ” СЭДЭВТ ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТ БОЛОВ



Батлан хамгаалахын сайдын 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 19 дүгээр тушаалаар “Оперативын факультет” гэсэн нэртэйгээр анх байгуулагдаж, 1996 онд “Команд штабын институт”, 1999 онд “Батлан хамгаалахын удирдлагын академи” болон өргөжиж эдүгээ цэргийн дээд боловсролтой, магистрын зэрэгтэй 310 офицерыг, мэргэшүүлэх сургалтаар 1000 орчим офицер, ахлагчийг сургаж төгсгөжээ.

ҮБХИС-ийн 2021-2022 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд БХУА-ийн эрдмийн хамт олон “Төрийн цэргийн

байгууллагын хөгжлийн стратеги-Батлан хамгаалахын удирдлагын академийн сургалт” сэдэвт багш нарын заах арга зүйн цугларалтыг хичээлийн шинэ жилийн өмнө буюу 8 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Энэхүү цугларалтын зорилго нь багш нарын цэрэг-стратегийн мэдлэгийг дээшлүүлэх, оператив-тактикийн сургалт явуулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, хичээл сургалтын бэлтгэлийг хангахад чиглэсэн бөгөөд тус сургалтад УАБЗ-ийн Ажлын алба, БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ОБЕГ, ДЦШ болон төрлийн цэргийн командлал,

удирдах газраас холбогдох удирдах албан тушаалтнууд оролцож, байгууллагынхаа үйл ажиллагааны өнөөгийн байдал, бодлого, зорилт, хөгжлийн чиг хандлагын талаар танилцуулга мэдээлэл хийгдэв.

Өчигдөр зохион байгуулагдсан хичээлийн шинэ жилийн нээлтэд тус академийн захирал, хурандаа С.Ванчинхүү багш, сонсогчидтой нээлтийн хичээлийг зохион байгуулж, энэ хичээлийн жилд хэрхэн суралцах талаар бие бүрэлдэхүүнд чиглэсэн үүрэг өгч, сургалтын амжилт хүссэн юм.

Батлан хамгаалах салбарын удирдах бүрэлдэхүүнийг бэлтгэн

гаргадаг ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академи нь 2021-2022 оны хичээлийн жилд Зэвсэгт хүчний 27 нэгтгэл, анги, Хил хамгаалах байгууллагын 6, Онцгой байдлын байгууллагын 2, Дотоодын цэргийн 1, нийт 36 сонсогч элсэн суралцаж байгаа юм.

Ташрамд сонирхуулахад БХУА-ийн хичээл сургалт нь ашиглалтад хүлээн авсан шинэ хичээлийн байрандаа холбогдох мэргэжлийн байгууллагаас тогтоосон халдварт цар тахлын дэглэмийг баримтлан танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулагдах юм.

## “СОЁМБОТ” ЦЭВЭР УС ISO 9001:2015 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ



Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний “Батлан хамгаалах аж үйлдвэрийн төсөл хэрэгжүүлнэ” гэсэн зорилт, арга хэмжээний хүрээнд 2018 онд “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ-ийн харьяанд “Соёмбот” цэвэр усны үйлдвэр байгуулагдсан.

Тус үйлдвэр нь цэвэр усны үйлдвэрлэл явуулах стандартад нийцсэн тоног төхөөрөмжтэйгөөр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Батлан хамгаалах салбар Зэвсэгт хүчин болон 70 гаруй супермаркет, 10 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллаж, стандартын шаардлага хангасан цэвэр усыг үйлдвэрлэдэг юм.

Тэгвэл тус үйлдвэрийн үйлдвэрлэдэг “Соёмбо” цэвэр ус нь ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж эхэллээ. Ингэснээрээ хэрэглэгчдээ эрхэмлэсэн чанартай бүтээгдэхүүнийг өдөр тутам хэрэглэх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Сонирхуулахад “Соёмбот” цэвэр усны үйлдвэр нь 24 цагт 0.5 литрээр 10 мянга гаруй цэвэр ус үйлдвэрлэх хүчин чадалтай юм.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
20	6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
30	23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.848.0	2.850.0
EUR	3.358.0	3.370.0
CNY	441.0	442.0
RUB	38.20	39.40
JPY	25.41	26.16
KRW	2.40	2.49

### ЗУРХАЙ

2021.9.2 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 26/

ӨГЛӨГТ ОХИН ОДТОЙ, ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Нүд бүрэлзэн улцайна

Наран ургах, шингэх:

06.12-19.32

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал:

уул

Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, угаал үйлдэх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Улааны үйлд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсоод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ


НИЙТ БҮРТГЭГДСЭН 218,541	ЭДГЭРСЭН 197.306	НАС БАРСАН 944
+3726	+3177	+7

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4629	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 174	ЭДГЭРСЭН 4366
+81	+19	+22

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 219,264,647
Эдгэрсэн Нийт: 196,041,211
Нас барсан Нийт: 4,545,125



ЦАХИМ ШУУДАНД

## ХОЁР АЛБА ХААГЧИЙН ХҮҮХДИЙГ ДЭЭД СУРГУУЛЬД СУРГАХ БАТЛАМЖ ГАРДУУЛАВ



Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одонт “Бөртэ” ТӨААТҮГ нь нийгмийн хариуцлагын хүрээнд олон ажлуудыг хийж хэрэгжүүлсээр ирсэн. Энэ хүрээнд тус үйлдвэрийн харилцагч байгууллага болох “Тэнгэр” дээд сургуультай хамтын ажиллагааны хүрээнд үйлдвэрт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа оёдлын 1 дүгээр тасгийн оёдолчин Д.Лхагвасүрэн, 2 дугаар тасгийн оёдолчин

Б.Амаржаргал нарын хөдөлмөр зүтгэлийг үнэлж урамшуулахын зэрэгцээ тэдний 2 хүүхдийг сонирхсон мэргэжлээр нь тус сургуульд 4 жилийн хугацаанд үнэ төлбөргүй суралцах эрхийн бичгийг гардуулан өглөө. Батламж гардуулах үеэр “Бөртэ” ТӨААТҮГ-ын дарга, хурандаа н.Энхтайван “Боловсрол гэдэг бол өнөөгийн нийгэмд хүн бүрийн эрхэмлэх хамгийн дээд баялаг. Тиймээс бид

хамт олноороо ярилцаад хөдөлмөр зүтгэлийг үнэлж, тэргүүний оёдолчдынхоо хоёр хүүхдийг “Тэнгэр” дээд сургуульд өөрсдийнх нь сонирхсон мэргэжлээр суралцуулахаар боллоо. Тиймээс хүссэн мэргэжлээрээ ажилттай, чармайлттай суралцан эх орондоо хэрэгтэй иргэд нь болоорой гэсэн бидний сэтгэлийн үгийг дамжуулаарай” хэмээн захилаа.

## ДЕЛЬТА ДАВЛАГАА ЭХЭЛЛЭЭ

Сүүлийн 24 цагт халдварын 3726 тохиолдол батлагдаж долоон хүн нас барлаа. Наймдугаар сарын дунд үеэс хойш өдөрт бүртгэгдэж буй тохиолдлын дундаж 2000 орчим байсан бол өнөөдөр 3700 гаруй бүртгэгдсэн нь халдварын дараагийн давлагаа эхэлсний дохио юм. Энэ талаар Эрүүл

мэндийн яамнаас дельта давалгаа эхэлж байгааг мэдээлэв. ЭМЯ-ны зүгээс “Дельта давалгаа эхэллээ. Өвдөхгүй байхад л хүн бүр анхаарч, дэглэмээ баримталж, олон хүн цугларсан газар очихгүй байх, амны хаалт авч үйлчлүүлдэг газраар үйлчлүүлэхгүй байхад анхаарна уу” гэв.



ФОТО АГШИН

### Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн шүжэрчин дайчид 2020 он



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

## ОРЧИН ЦАГИЙН АРТИЛЛЕРИЙН ЦЭРГИЙН 100 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ...



# Артиллерийн цэрэг 100 жил

Орчин цагийн артиллерийн цэргийн 100 жилийн ойн тохиолдуулан МАЦХ-ны тэргүүн хошууч генерал Б.Баярмагнай холбооны удирдах зөвлөлийн гишүүд, тэдний гэр бүлийг өөрийн зусландаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэв. Тус арга хэмжээний хүрээнд удирдах зөвлөлийн гишүүд Артиллерийн

цэргийн 100 жилийн ойг нийт Артиллерчид тэдний гэр бүл үр хүүхдүүдийг хамруулан тэмдэглэн өнгөрүүлэх, хийгдэж байгаа ажлуудаа эрчимжүүлэхээр талаар хэд хэдэн төлөвлөгөөг боловсруулав. Мөн энэ үеэр тэдний дунд модон бөмбөгийн тэмцээн зохион байгуулж эхний байрыг Г.Баатарнум,

удаах байрыг Дагвасүрэн, гутгаар байрыг Ж.Ванчинсүрэн нар эзлэж Холбооны тэргүүн Б.Баярмагнай, өөрийн аав Бямбасүрэнгийн хамт тэмцээнд шалгарасдыг шагнаж урамшууллаа. Энэ үеэр хошууч генерал Б.Баярмагнай Артиллерийн 100 жилийн ойд зориулж хувиасаа 500.000 төгрөг хандивласан юм.



ДЭЛХИЙД

## “ASTRA SPACE” ПУУЖИН ТЕХНИКИЙН АСУУДЛААС БОЛЖ ТОЙРОГ ЗАМД ХҮРЧ ЧАДСАНГҮЙ



“Astra Space” компанийн ням гарагт хөөргөсөн туршилтын пуужин тойрог замд хүрч чадсангүй. Тэрхүү жижиг оврын пуужинг хиймэл дагуулыг сансарт гаргах зориулалтаар

хөгжүүлсэн байна. 13 орчим метр өндөртэй пуужин газраас хөөрөхдөө тогтворгүй байсныг “Astra Space” мэдээллээ. Мөн хоёр минут гаруй хөөрсөн нислэгийн мэдээлэлд дүн

шинжилгээ хийнэ гэдгээ мэдэгджээ. “Astra Space”-ийн хувьцааны ханш долдугаар сард огцом буураад байсан бол өнгөрсөн долоо хоногт 21 гаруй хувиар өсжээ.